Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажил үүрэгт хийсэн баримтын шинжилгээ

П.Ариунжаргал[1], М.Сугармаа[1], С.Хандмаа[2]

[1]АШУҮИС, Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
[2]АШУҮИС, Багшийн хөгжил, цахим сургалтын газар
Цахим хаяг: ariunjargal.mnums@gmail.com, Утас: 90458789

Түлхүүр үг:

Мэргэжлийн үүрэг
Чанарын судалгаа

Товч утга: Эрүүл мэндийн сайдын А/289 тоот тушаалаар 2018 онд Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлагдсан ба тус үлгэрчилсэн загварын дагуу ажлын байрны тодорхойлолтууд боловсруулж, мөрдөн ажиллаж буй энэ үед ажлын байрны тодорхойлолтуудад агуулгын шинжилгээ хийх шаардлагатай байна. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод агуулгын шинжилгээ хийж, харьцуулах зорилгыг дэвшүүлэв. Судалгаанд чанарын судалгааны баримтын шинжилгээний аргыг ашиглан эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний нийт 18 ажлын байрны тодорхойлолтод Жигелевскийн (1998) дэвшүүлсэн эрүүл мэндийн нийгмийн ажилтны үүргийн ангиллын дагуу агуулгын шинжилгээ хийв. Судалгааны үр дүнгээс үзэхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатлалд эрүүл мэндийн нийгмийн ажилтан клиник үүрэг гүйцэтгэж ажилладгаараа нийгмийн эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэж буй үүргээс ялгаатай байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний лавлагаа шатлалд ажиллаж буй эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажил үүрэгт клиник үүрэг өндөр, мэргэжлийн удирдлага бага гүйцэтгэдэг бол нийгмийн эрүүл мэндийн ажилтны хувьд клиник үүрэг бага, мэргэжлийн удирдлагын үүрэг өндөр байна.

Үндэслэл: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг олон мэргэжлийн оролцоотой хэрэгжүүлэх нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу АШУҮИС-д 2020 оны байдлаар нийт 251 эрүүл мэндийн нийгмийн ажилтан бэлтгэгдсэн ба тэдний ажил үүргийн талаар 2009, 2013, 2016, 2018 онуудад судалгаа хийгджээ. Тодруулбал, 2009 онд Б.Ариунсанаа нарын судалгаанд Улаанбаатар хотын өрх, дүүргийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтнуудын гүйцэтгэж буй ажил үүрэг нь нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад чиглэж байжээ.[1] 2013 онд Т.Гүрбазар нарын судалгаанд эрүүл мэндийн нийгмиийн ажилтнуудын ажлын байрны үндсэн ажлын хүрээнд сургагчийн болон хувь хүнтэй ажиллах нийгмийн ажлын үүргийг түлхүү гүйцэтгэж байгааг тодорхойлжээ.[2] 2016 онд хийсэн С.Хандмаа нарын "Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс" сэдэвт судалгаагаар Улаанбаатар хотын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ажилладаг 140 эрүүл мэндийн нийгмиийн ажилтнуудыг хамруулж, эмнэлгийн байгууллагад эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажлын шаардлага, ачаалал их байгааг илрүүлж, ажлын байрны тодорхойлолтод захиргааны үүрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх шатлалд давамгайлж байгааг тодорхойлсон.[3] 2018 онд Д.Мөнх-Учрал нарын судалгаанд эрүүл мэндийн нийгмийн ажилтан мэргэжлээр төгсөгчдийн 96.9 хувь нь хөдөлмөр эрхэлдэг ба үүнээс эрүүл мэндийн салбарт 93.6 хувь, тэдний 50 хувь нь эрүүл мэндийн нийгмийн ажилтан орон тоогоор ажиллаж байжээ.[4] Ц.Мөнхнасан нарын судалгаанд нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь үндэсний төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлд түлхүү ажилладаг бол эрүүл мэндийн нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын мэргэжлийн интервенц тусламж үйлчилгээ үзүүлэхэд түлхүү ажилладаг үр дүн гарчээ.[5] Б.Хишигбуян нарын


судалгаанд эрүүл мэндийн нийгмийн ажилтан мэргэжлээр төгсөгчид I, II, III шатлалд нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр хариуцах, сургалт судалгаа хийх, эрүүл мэндийн боловсрол олгох үүргийг голлон гүйцэтгэж байгааг тодорхойлжээ.[6] Эрүүл мэндийн сайдын А/289 тоот тушаалаар 2018 онд Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлагдсан.[7] Мөн энэхүү чиг үүргийг нийгмийн эрүүл мэндийн ажилтан ажлын байрны тодорхойлолтод тусган хэрэгжүүлж байгаа учраас эрүүл мэндийн нийгмийн ажилтан болон нийгмийн эрүүл мэндийн ажилтны ажил үүргийн ялгаатай байдлыг судлах шаардлагатай.

Зорилго: Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод агуулгын шинжилгээ хийж, харьцуулах

Арга: Судалгаанд чанарын судалгааны баримтын шинжилгээний аргыг ашиглан өрхийн эрүүл мэндийн төвийн 3, дүүргийн эрүүл мэндийн төвийн 3, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2, тусгай мэргэжлийн төвийн 2, сумын эрүүл мэндийн төвийн 3, сум дундын эмнэлгийн 2, аймгийн нэгдсэн эмнэлгийн 2, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 1, нийт 18 ажлын байрны тодорхойлолтод агуулгын шинжилгээ хийв. Үүнд, эрүүл мэндийн нийгмийн ажилтны 7, нийгмийн эрүүл мэндийн ажилтны 9, нэм-ийн төсөл хөтөлбөрийн зохицуулагч 1, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажилтны 1 ажлын байрны тодорхойлолт байсан ба Жигелевскийн (1998) дэвшүүлсэн эрүүл мэндийн нийгмийн ажилтны 4 цөм үүргийн дагуу ангилан, үр дүнг боловсруулав.[8]


Үр дүн: Ажлын байрны тодорхойлолтын дагуу 43.7 хувь нь эрүүл мэндийн нийгмийн ажилтан, 56.3 хувь нь нийгмийн эрүүл мэндийн ажилтан албан тушаалтан байв. Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажил үүргийн салшгүй хэсэг нь ажлын байрны тодорхойлолтын асуудал байдаг.[9]

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг анхан шатлалд хүргэж буй байгууллагуудаас сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт нийгмийн эрүүл мэндийн ажилтан албан тушаалтан ажиллаж байгаа ба ажлын байрны тодорхойлолтод захиргааны үүрэг 8.97 хувь, олон нийтийн үүрэг 15.3 хувь, бусад үүрэг 3.84 хувь тусгагдсан байгаа ба клиник болон мэргэжлийн удирдлагын үүрэг тусгагдаагүй байна. Өрхийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн нийгмийн ажилтан албан тушаалтан ажиллаж байгаа ба ажлын байрны тодорхойлолтод клиник үүрэг 2.56 хувь, захиргааны үүрэг 6.41 хувь, олон нийтийн үүрэг 6.41 хувь, бусад үүрэг 1.28 хувь тусгагдсан ба мэргэжлийн удирдлагын үүрэг огт тусгагдаагүй байна (Зураг 1).



Зураг 1. ЭМАШТҮ дэх эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний ажил үүрэг

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний лавлагаа шатлалын байгууллагуудаас аймгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд нийгмийн эрүүл мэндийн ажилтан ажилладаг ба ажлын байрны тодорхойлолтод клиник үүрэг 1.28 хувь, мэргэжлийн удирдлагын үүрэг 2.56 хувь, захиргааны үүрэг 8.97 хувь, олон нийтийн үүрэг 6.41 хувь ба бусад үүрэг 3.84 хувь тусгагдсан байна. Дүүргийн эрүүл мэндийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд эрүүл мэндийн нийгмийн ажилтан ажилладаг ба ажлын байрны тодорхойлолтод клиник үүрэг 3.84 хувь, мэргэжлийн удирдлагын үүрэг 1.28 хувь, захиргааны үүрэг 8.97 хувь, олон нийтийн үүрэг 7.69 хувь, бусад үүрэг 1.28 хувь тусгагдсан байна (Зураг 2).



Зураг 2. ЭМТҮ-ний лавлагаа шатлалд ажиллаж буй эрүүл мэндийн нийгмийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний ажил үүрэг

Хэлцэмж: Манай улсад 2018 онд Эрүүл мэндийн сайдын А/289 тоот тушаалаар Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлагдан гарсан ба үүнээс хойш эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ажиллаж буй эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажил үүргийн өнөөгийн нөхцөл байдлыг чанарын судалгааны аргаар тодорхойлсон нь бидний судалгааны онцлог юм. Бидний судалгаанд ашигласан судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнтэй ижил төстэй арга зүйгээр хийгдсэн судалгааны ажлыг сонгон хэлцэмждээ тусгав. 2016 онд

С.Хандмаа, М.Сугармаа нарын “Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан үүргийг судлах нь” сэдэвт судалгаагаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал тус бүрийн эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг сонгон судлаач Жигелевскийн (1998) дэвшүүлсэн эрүүл мэндийн нийгмийн ажилтны дөрвөн цөм үүрэг буюу клиник, захиргааны, мэргэжлийн удирдлагын, олон нийтийн үүргүүдэд хуваан баримт бичгийн агуулгын шинжилгээний аргаар судалсан байна.[10] Судалгааны үр дүнд өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод захиргааны үүрэг 37.5 хувь, клиник үүрэг 25 хувь, олон нийтийн үүрэг 25 хувь, мэргэжлийн удирдлагын үүрэг 8.3 хувь, бусад үүрэг 4.2 хувь тусгагджээ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хоёрдугаар шатлалд ажиллаж буй нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийг авч үзвэл захиргааны үүрэг 50 хувь, мэргэжлийн удирдлагын болон клиник үүрэг тус бүр 1.8 хувь, олон нийтийн үүрэг 9 хувь тусгагдсан бол бусад үүрэг 4.5 хувь байна. Харин төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийг авч үзэхэд захиргааны үүрэг 52.5 хувь, клиник үүрэг 42.8 хувь, бусад үүрэг 4.7 хувь байсан бол мэргэжлийн удирдлагын болон олон нийтийн үүрэг тусгагдаагүй байна.[10]

Жигелевскийн (1998) дэвшүүлсэн эрүүл мэндийн нийгмийн ажилтны цөм үүрэг буюу клиник, мэргэжлийн удирдлага, олон нийт, захиргааны үүрэг нь эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтын 95.6 хувьд тусгагдсан бол захиргааны үүрэг 46.7 хувь, клиник үүрэг 28.7 хувь, мэргэжлийн удирдлагын үүрэг 8.8 хувь, олон нийтийн үүрэг 11.4 хувийг тус тус эзэлж байгаа үр дүнг тодорхойлжээ.[10] Харин бидний судалгаагаар өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг ашиглан Жигелевскийн (1998) үүргийн ангиллаар судлан үзэхэд клиник үүрэг 15.3 хувь, захиргааны үүрэг 38.4 хувь, олон нийтийн үүрэг 38.4 хувь, бусад үүрэг 7.69 хувь тусгагдсан ба мэргэжлийн удирдлагын үүрэг огт тусгагдаагүй байлаа.

Мөн дүүргийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг ашиглан авч үзэхэд клиник үүрэг 7.69 хувь, мэргэжлийн удирдлагын үүрэг 23 хувь, захиргааны үүрэг 30.7 хувь, олон нийтийн үүрэг 30.7 хувь, бусад үүрэг 7.6 хувь тусгагдсан үр дүн гарлаа. Харин төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг судлахад клиник үүрэг 16.6 хувь, захиргааны үүрэг 66.6 хувь, олон нийтийн үүрэг 16.6 хувь тусгагдсан байгаа ба бусад болон мэргэжлийн удирдлагын үүрэг огт тусгагдаагүй байна. Үүнээс үзэхэд өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд захиргааны болон олон нийтийн үүргийг түлхүү гүйцэтгэдэг гэсэн ижил үр дүн гарсан ба клиник болон мэргэжлийн удирдлагын үүрэг харьцангуй буурсан байна. Дүүргийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд захиргааны үүргийг хамгийн их гүйцэтгэдэг хэвээр байгаа нь дээрх судалгааны үр дүнтэй ижил байгаа ба клиник, мэргэжлийн удирдлага, олон нийтийн үүрэг өссөн ялгаа харагдаж байна. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн түвшинд эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд захиргааны үүрэг хамгийн их гүйцэтгэдэг, мэргэжлийн удирдлагын үүрэг огт тусгагдаагүй зэрэг нь дээрх судалгааны үр дүнтэй ижил байгаа ба клиник болон бусад үүрэг буурсан, олон нийтийн үүрэг өссөн ялгаа ажиглагдлаа.

Өмнө хийгдсэн судалгааны нийт үр дүнд эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд захиргааны болон клиник үүргийг түлхүү гүйцэтгэж байсан бол бидний судалгаагаар захиргааны болон олон нийтийн үүргийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх түвшинд хамгийн их гүйцэтгэж байгаа үр дүн гарлаа. Энэ нь эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд захиргааны үүрэг гүйцэтгэж буй байдал өнөөг хүртэл хэвээр байгааг илтгэж байна. Мөн эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд мэргэжлийн удирдлагын үүрэг гүйцэтгэж буй байдал өмнөх болон одоогийн судалгаануудад маш бага тодорхойлогдож байгаа нь цаашид энэ үүргийг практикт түлхүү хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна.

Дүгнэлт: Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн нийгмийн ажилтан клиник үүрэг гүйцэтгэж ажилладгаараа нийгмийн эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэж буй үүргээс ялгаатай байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний лавлагаа шатлалд эрүүл мэндийн нийгмийн ажилтан клиник үүрэг их, мэргэжлийн удирдлага бага гүйцэтгэдэг бол нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь клиник үүрэг бага, мэргэжлийн удирдлагын үүрэг их гүйцэтгэж ажилладаг ялгаатай байна.

Ном зүй:

1. *Б.Ариунсанаа, Х.Дамдинжав, М.Сугармаа, О.Саранчулуун, С.Хандмаа. Эрүүл мэндийн салбар дах нийгмийн ажилтны хэрэгцээ: Бэрхшээл ба сургамж. Нийгмийн ажил сэтгүүл. 2010. 25-28*
2. *Т.Гурбазар, Ц.Нямсүрэн. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагааны өнөөгийн байдал. Нийгмийн ажил сэтгүүл. 2013. 7-10.*
3. *С.Хандмаа, О.Мөнхбат, М.Сугармаа. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны нийгэм-сэтгэл зүйн зарим хүчин зүйлсийг судалсан дүн. Эрдмийн чуулган-60 Илтгэлийн хураангуй. 2018. 14-15.*
4. *Д.Мөнх-Учрал. Эрүүл мэндийн нийгмийн ажилтан мэргэжлээр төгсөгчдийн талаарх ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа. Нийгмийн эрүүл мэндийн эрин сэтгүүл. 2020. 127-129.*
5. *Р.Энхбат, Ц.Мөнхнасан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын гүйцэтгэж буй үүрэг оролцоо.Эрүүл мэндийн нийгмийн ажлын сайн туршлага, хамтын ажиллагаа, хөгжлийн хандлага. 2018. 21-14.*
6. *Б.Хишигбуян, Г.Надмидцэрэн. ЭМНА төгсөгчдийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа. Эрүүл мэндийн нийгмийн ажлын сайн туршлага, хамтын ажиллагаа, хөгжлийн хандлага. 2018. 69-71.*
7. *Эрүүл Мэндийн Яам. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар. Монгол Улс. Улаанбаатар хот. 2018.1-5*
8. *Sophia E. Dziegielewski. The changing face of health care social work: Professional practice in the era of managed care. New York: Springer Publishing Company. 1998. 101-105*

9. Muammer Sarikaya, Senay Yurur. The effects of workload, role ambiguity, and social support on burnout among social workers in Turkey. Administration in Social work. vol. 36. 2012. 457-474.
10. С.Хандмаа, О.Мөнхбат, М.Сугармаа. Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан үүргүүдийг судлах нь. Эрдмийн чуулган-60 Илтгэлийн хураангуй. 2018. 117.

Content analysis on job descriptions of health social workers

Ariunjargal.P[1], Sugarmaa.M[1], Khandmaa.S[2]

[1]School of Public Health, MNUMS
[2]Division for faculty development and e-learning,MNUMS
Email: ariunjargal.mnums@gmail.com, Tel: 90458789

In 2018, sample job description of health social workers is issued by Minister of Health's order as number A/289. Job descriptions of health social workers in health care settings have revised for last two years in order to reconcile into the sample job description. Therefore, it is essential to do content analyses on the job descriptions. Aim of study was to do content analyses on job descriptions of health social workers and, to compare the roles of health social workers and public health worker, its levels of health care settings. The study was conducted using content analysis, a qualitative research method, involving total of 18 job descriptions of either health social worker or public health workers. The content analysis is based on Dziegielewski's health social workers' core roles. The study result shows that health social workers perform more clinical role in primary health settings compared to public health workers that have no clinical roles in the job descriptions. In secondary and tertiaty care settings, health social workers perform prevailing clinical roles compared to public health workers that perform supervisional roles.

Keywords: Professional role, qualitative research